

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг



**БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгууллагын нэр:

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Баталгаажуулсан:

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**  
(албан тушаал)

Тэмдэг

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**

  
.....  
(гарын үсэг)  
2022.01.....  
(огноо)

/А.АРИУНЗАЯА/

Төлөвлөгөө боловсруулсан:

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА**  
(албан тушаал)

Тэмдэг

**Төсвийн Шууд захирагч**

  
.....  
(гарын үсэг)  
2022.01..  
(огноо)

/Д.ЗОРИГТ/

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
1	2	3	4	5	6	7	8
<b>Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.</b>							
<p><i>“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i></p>							
1.1.	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой нийгмийн даатгалын дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн батлуулах талаар холбогдох саналыг боловсруулан шаардлагатай судалгаа, тооцооны хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаардлагагүй	Боловсруулсан санал	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/73 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их хуралд өргөн барив.	Шаардлагатай судалгаа тооцооны хамт санал боловсруулан хүргүүлсэн байна.	I-IV улирал	БХСГ
1.2.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох журам, заавар, зөвлөмж, чиглэлийг боловсруулан батлуулж төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;	Шаардлагагүй	Журам, заавар, зөвлөмж, чиглэлийн тоо	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 22 удаагийн чиглэл, зөвлөмж, 6 журмыг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэх чиглэлээр орсон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэн журам, заавар, чиглэл боловсруулан төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна. Жилийн эцэст, хүргүүлсэн журам, заавар, чиглэл,	I-IV улирал	БХСГ

					зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.		
1.3.	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаард- лагагүй	Хуулийн дагуу шимтгэлээ төлсөн иргэдийн баталгаажилтын хуудсыг хэвлэсэн тоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн тайлан	2021 онд урьдчилсан байдлаар нийт дүнгээр 24.9 мянган иргэнийг тэтгэврийн нөхөн даатгалд хамруулснаар 52.3 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлэв.	Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулсан үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	I улирал	БХСГ
1.4.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оноос эхлэн дагаж мөрдөхтэй холбоотойгоор уг хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Шаард- лагагүй	Нийгмийн даатгалын харилцаатай холбогдолтой зүйл, заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж	Шинээр хэрэгжинэ.	Зөвлөмж хүргүүлсэн байна. Жилийн эцэст зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
1.5.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 71 дүгээр зүйлд заасан туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээ бүхий иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалд хамруулах ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран зохион байгуулах;	Шаард- лагагүй	Хамтран ажиллах гэрээ	Шинээр хэрэгжинэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хооронд гэрээ байгуулах талаар хамтран ажиллах санал авсан байна. Жилийн эцэст хоёр байгууллагын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулан, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.	I-IV улирал	БХСГ
1.6.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож, Үндэсний статистикийн хорооноос санал авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр	Шаард- лагагүй	Батлагдсан хүүгийн хэмжээ	Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тооцож Үндэсний статистикийн хорооноос санал авч Нийгмийн даатгалын үндэсний	Нэрийн дансны хүүгийн хэмжээг тооцон, Үндэсний статистикийн хорооны саналыг авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулсан байна.	IV улирал	БХСГ

	хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;			зөвлөлийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор 2021 оны хүүгийн хэмжээг 11.6 хувиар батлуулав.			
1.7.	Нэрийн дансны 2021 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчдад мэдээлэл хүргэх;	Шаард-лагагүй	Нэрийн дансны үлдэгдлийн хэмжээ	2020 оны жилийн эцсийн байдлаар 1.5 сая даатгуулагчийн 18.8 их наяд төгрөгийн шимтгэлийг хүүгийн хамт бүртгэсэн.	Нэрийн дансны 2021 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчид мэдээлсэн байна.	II улирал	БХСГ
1.8.	“Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоох нь” сэдэвт сургалтыг салбарын нийт ажилтнуудын дунд үе шаттайгаар зохион байгуулах;	Шаард-лагагүй	Зохион байгуулсан сургалтын тоо	Шинээр хэрэгжинэ.	“Нэрийн дансны аргаар тэтгэвэр тогтоох нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна.	II улирал	БХСГ СОНХАГ
1.9.	Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах;	Шаард-лагагүй	Шинээр нийгмийн даатгалд хамруулсан сайн дурын даатгуулагч, малчдын тоо	2021 онд 40.6 мянган иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. Үүнээс 2.4 мянган малчныг нийгмийн даатгалд шинээр хамруулав.	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, жилийн эцэст гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
1.10.	Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сангийн орлогын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчдыг шинээр хамруулах ажлыг зохион байгуулах;	Шаард-лагагүй	Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо	2021 онд 4.7 мянган аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр бүртгэж, 130.4 мянган иргэнийг албан журмын даатгалд хамруулсан.	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, жилийн эцэст гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
1.11.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний	1.57 тэрбум төгрөг	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, хийж гүйцэтгэсэн ажлын тоо	Төлөвлөгөөнд тусгагдсан 34 ажлыг хийж гүйцэтгэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 785.9 тэрбум төгрөгийг зарцуулав.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулсан байна.	I-IV улирал	БХСГ

	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үр дүнг сурталчлан ажиллах;						
1.12.	Өндөр насны тэтгэвэр тогтоохтой холбоотой 2022 онд мөрдөх хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэдэд хуулийг сурталчлан таниулах, төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Шаардлагагүй	Хүргүүлсэн чиглэл, зөвлөмжийн тоо	2021 онд 353.8 мянган тэтгэвэр авагчийн өндөр насны тэтгэвэр 1,790.4 тэрбум төгрөгийг зарцуулсан. Төв, орон нутгийн албадад 3 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн.	Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
1.13.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоох, олгох ажлыг зохион байгуулан, хууль тогтоомжид орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх чиглэлээр төв, орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Шаардлагагүй	Хүргүүлсэн чиглэл, зөвлөмжийн тоо	2021 онд 19.7 мянган цэргийн тэтгэвэр, тэтгэмжид 162.1 тэрбум төгрөгийг зарцуулсан. Төв, орон нутгийн албадад 2 удаагийн чиглэл, зөвлөмжийг хүргүүлсэн.	Хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл, зөвлөмж өгч, мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
<b>Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>							
"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоолын дагуу орлогын гүйцэтгэлийг хангуулсан байна.	Нийгмийн даатгалын санд 2 397.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	Нийгмийн даатгалын санд 2 840.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.2.	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр,	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн	Нийгмийн даатгалын сангаас 2 594.3 тэрбум төгрөг олгосон.	Нийгмийн даатгалын сангаас 2 750.9 тэрбум төгрөг олгоно.	I-IV	СБГ

	тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох;		хуваарь батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу зарлагын гүйцэтгэлийг хангуулсан байна.			улирал	
2.3.	Нийгмийн даатгалын байгууллагуудад сангийн болон үйл ажиллагааны урсгал санхүүжилтийг шилжүүлэх;	-	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “2022 оны төсвийн хуваарь батлах тухай” 23 дугаар тогтоолын дагуу санхүүжилт олгосон байна.	Нийгмийн даатгалын байгууллагуудад 1 058.1 тэрбум төгрөгийн сан болон урсгал зардлын санхүүжилт олгосон.	Нийгмийн даатгалын байгууллагуудад 1 157.9 тэрбум төгрөгийн сан болон үйл ажиллагааны урсгал зардлын санхүүжилт олгоно.	I-IV улирал	СБГ
2.4.	Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу шимтгэлийн орлогыг цуглуулах, төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар хооронд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний заалт хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 398.2 тэрбум төгрөг шилжүүлсэн.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар руу Даваа гариг бүр төвлөрсөн орлогыг шилжүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.5.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 15.0 хувиас хэтрүүлэхгүй байх;	-	Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хувийг нэмэгдүүлээгүй байна.	Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага орлогын 14.9 хувийг эзэлсэн.	Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага орлогын 15.0 хувийг эзэлнэ.	I-IV улирал	СБГ
2.6.	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулсан байна.	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг бүрэн зохион байгуулсан.	Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	I-IV улирал	СБГ
2.7.	Нийгмийн даатгалын сангийн болон урсгал зардлын гүйцэтгэлийн дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулах;	-	Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Төсвийн гүйцэтгэлийн 12 удаагийн мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.8.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.9.	Нийгмийн даатгалын	-	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын		

	сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэх ажил зохион байгуулах;		үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлсэн байна.	үндэсний зөвлөлөөс нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг байршуулах санал тооцоолол, хамтарсан шийдвэрийн саналын төслийг Сангийн яам, Монгол банкинд хүргүүлсэн боловч 2020 онд Сангийн яам, Монгол банк, 2021 онд Сангийн яамнаас зөвшөөрөөгүй тул тухайн онуудад хөрөнгийн дээд хэмжээ батлагдаагүй болно.	үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэн нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкуудад хугацаатай байршуулна.	I-IV улирал	СБГ
2.10.	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагаар хангах;	-	Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулж, "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн шийдвэр гарсан байна.	"Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн шийдвэр гарсан.	Өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулна.	I-IV улирал	СБГ
2.11.	Үндсэн хөрөнгө шилжүүлэх, устгах саналыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгалын байгууллагуудад хөрөнгө хүлээн авах, хөдөлгөөн хийх, хуваарилах, хэрэгжилтэд хяналт тавих;	-	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгийг хуваарилах, бүртгэх, бусдад хуваарилах, бүртгэх, бусдад худалдах, шилжүүлэх, данс бүртгэлээс хасах тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангасан байна.	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой шийдвэр хэрэгжсэн.	Нийгмийн даатгалын байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг хэрэгжүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.12.	Нийгмийн даатгалын байгууллагуудтай Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн орлогыг санд төвлөрүүлэхэд хяналт тавих;	-	Нийгмийн даатгалын байгууллагуудын түрээсийн гэрээний үүргийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.	Түрээсийн 80.0 сая төгрөгийн орлого орсон.	Түрээсийн гэрээг хугацаанд нь байгуулан түрээсийн орлогыг нийгмийн даатгалын санд бүрэн төвлөрүүлнэ.	I-IV улирал	СБГ
2.13.	Нийгмийн даатгалын		Төрийн өмчийн бодлого,	Нийгмийн даатгалын нийт 32	"Төрийн өмчийг эзэмшүүлэх	I-IV	СБГ

	байгууллагуудын “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд хяналт тавьж ажиллах;	-	зохицуулалтын газрын журмын дагуу “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулах, дүгнүүлэхэд шаардагдах баримт материалыг бүрдүүлэн хугацаанд нь хүргүүлсэн байна.	байгууллага “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулж, дүгнүүлсэн.	гэрээ”-г шинэчлэн байгуулж, дүгнүүлнэ.	улирал	
2.14.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулах;	-	Монголбанкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын сангийн өр авлагад Капитал банкны шилжүүлсэн хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаагаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар “Журам батлах тухай” тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 268 дугаар “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, 269 дүгээр “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” тогтоол, Иргэний хуулийн 197 дугаар зүйл болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, худалдах, түрээслүүлэх	Шинээр хэрэгжинэ.	Нээлттэй худалдааг зохион байгуулна.	I-IV улирал	СБГ
2.15.	“Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх хүрээнд Нийгмийн систем төсөл”-ийн	-	Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн “GreenFinance” програмын туршилт,	Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн “GreenFinance” програмын	I-IV улирал	СБГ



	даатгалын салбарын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх;			нэвтрүүлэлтийг салбарын хэмжээнд эхлүүлсэн. Сангийн нягтлан бодох бүртгэлийн "Core" системийн хөгжүүлэлтийг төсөл хэрэгжүүлэгч "Ай Ти Зон" ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.	нэвтрүүлэлтийг салбарын хэмжээнд хэрэгжүүлнэ. Сангийн нягтлан бодох бүртгэлийн "Core" системийн туршин нэвтрүүлэлтийг төсөл хэрэгжүүлэгч "Ай Ти Зон" ХХК-тай хамтран хэрэгжүүлнэ.		
2.16.	Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн нийгмийн даатгалын албадад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Нийгмийн даатгалын сангийн орлого 2,840.4 тэрбум төгрөг (Улсын төсвийн татаас орсон дүн), зарлага 2,751.0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны урсгал зардал 32.4 тэрбум төгрөг	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, хуваарийн дагуу төсвийг олгосон байна.	Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг төв, орон нутгийн албадад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	Төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, Газрын даргын баталсан сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн уг хуваарийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, нийгмийн даатгалын байгууллагын урсгал зардлын төсвийг олгосон байна.	I-IV улирал	БХСГ
2.17.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсөөллийн саналыг төв, орон нутгийн нийгмийн даатгалын	Шаард лагагүй	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсөөллийн Газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Нийгмийн даатгалын байгууллагуудаас 2023-2025 оны төсвийн төсөл, төсөөллийг хүлээн авсан байна. Жилийн эцэст, төсвийн төслийг хянан Газрын даргын зөвлөлийн болон НДҮЗ-ийн гишүүдийн саналыг тусган Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь	II-III улирал	БХСГ

	албадаас хүлээн авч хянан боловсруулж, саналыг Газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх;				хэсэгт заасны дагуу 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.		
2.18.	Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах, сар, улирлын хуваарийг батлах, төв, орон нутгийн албадад хүргүүлэх;	Шаард лагагүй	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр батлуулан, Нийгмийн даатгалын хэлтсүүдэд байна.	2022 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, сар, улирлын хуваарийг батлан, төв, орон нутгийн албадад хүргүүлсэн.	2023 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр, сар, улирлын хуваарийг баталж төв, орон нутгийн албадад хүргүүлсэн байна.	IV улирал	БХСГ
2.19.	НД-7, НД-8 тайланг ажил олгогчоос тоон гарын үсгээр хүлээн авах ажлыг эрчимжүүлэх;	-	Тоон гарын үсгээр тайлан илгээх ажил олгогчийн тоо нэмэгдсэн байх	2021 онд 4.2 мянган ажил олгогчийн тоон гарын үсгээр илгээсэн тайланг хүлээн авсан.	Ажил олгогчоос тоон гарын үсгээр илгээсэн тайланг хүлээн авах ажлыг өргөжүүлсэн байна.	I- IV улирал	МТТ
2.20.	Нийгмийн даатгалын төв орон нутгийн албадыг нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны зардлын төсөв, төлөвлөгөө боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах;	Шаард лагагүй	Боловсруулсан төсөв, төсвийн төлөвлөгөө	Аймаг, дүүргээс ирүүлсэн нийгмийн даатгалын сангийн 2023-2025 оны төсвийн төслийг хянан нэгтгэж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг тусган 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор	Эхний хагас жилд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийг мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна. Жилийн эцэст нийгмийн даатгалын төсөв, төлөвлөгөө хийгдсэн байна.	II- III улирал	БХСГ

				Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.			
2.21.	Нийгмийн даатгалын салбарын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн нарийвчилсан үзүүлэлтээр баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх;	Шаардлагагүй	Хагас, бүтэн жилийн статистикаар шинэчилсэн байна.	2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн байдлаар статистик үзүүлэлтийг шинэчилсэн.	2022 оны эхний хагас жилд 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээр шинэчилсэн байна. 2022 оны жилийн эцэст 2022 оны эхний хагас жилийн үзүүлэлтээр шинэчилсэн байна.	II-III улирал	БХСГ
2.22.	Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягтыг Үндэсний статистикийн хороотой хамтран шинэчлэн боловсруулах;	Шаардлагагүй	Батлагдсан маягт	Уг ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороотой хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, гарсан саналыг тусган тодорхой бэлтгэл ажлыг ханган ажиллав.	Маягтыг шинэчлэн боловсруулах саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	IV улирал	БХСГ
<b>Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>							
<i>“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i>							
3.1.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэх;	Шаардлагагүй	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээ хийж, тайланг хуулийн хугацаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/14 тоот албан бичгээр болон цахимаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн явцад үнэлгээ хийгдэж хэрэгжилт биелсэн байна.	I-II улирал	ДАМГ
3.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Шаардлагагүй	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Үнэлгээний тайланг Нийгмийн даатгалын	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	I-IV улирал	ДАМГ

	хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;		хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж улирлын нэгдсэн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	ерөнхий газрын даргын 2021 оны 1/54, 1/604, 1/1154, 1/1645 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	хангагдаж мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.		
3.3.	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард-лагагүй	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 02 дугаар сарын 01-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/125 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт үе шаттай хангагдсан байна.	I улирал	ДАМГ
3.4.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Шаард-лагагүй	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 01 дүгээр сарын 20, 06 дугаар 20-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/67, 1/1020 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт үе шаттай биелсэн байна.	I-II улирал	ДАМГ
3.5.	Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн	Шаард-лагагүй	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 1/31 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд	Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт үе шаттай биелэгдсэн байна.	I-II улирал	ДАМГ

	хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;		үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	хүргүүлсэн байна.			
<p><i>"Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт" хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i></p>							
3.6.	Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, батлагдсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажил үйлчилгээний үр дүнг тооцож ажиллах;	30.0 сая	Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд Нийгмийн даатгалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, өмнөх шалгалтын мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж ажиллах	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Сонгинохайрхан дүүрэг болон Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгуудын Нийгмийн даатгалын хэлтэст шалгалт хийж илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоож 54.5 хувийг барагдуулж ажилласан.	Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу дурдсан аймаг, дүүргүүдийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн ажил үйлчилгээний үр дүнг тооцох, Улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөрийн 70-аас дээш хувийг барагдуулж ажиллах	I-IV улирал	ХШГ

3.7.	Малчны тэтгэврийн тогтоолт, олголтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож, олгосон байдалд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах;	10.0 сая	1-2 аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Малчны тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгаж, шалгалтын дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулах	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн малчны тэтгэвэр тогтоолт олголтыг шалгаж 60.9 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн 37.8 хувийг барагдуулж ажилласан.	Батлагдсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсүүдэд холбогдох хуулийн хэрэгжилтийг шалгаж, ажил үйлчилгээний үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	I-IV улирал	ХШГ
3.8.	Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод үйл ажиллагаа болон бусад чиглэлээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдийн хийж гүйцэтгэх хяналт шалгалтын ажлын нэгдсэн удирдамж боловсруулж хүргүүлэн, шалгуулах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж мэргэжил арга зүйгээр ханган ажиллах;	Шаард лагагүй	Нэгдсэн удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дотоодын хяналт шалгалтаар шалгуулах ажлыг зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, үр дүнг тооцож ажиллах	Шинээр хэрэгжинэ	Батлагдсан удирдамжийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсүүдэд холбогдох хуулийн хэрэгжилтийг шалгаж, ажил үйлчилгээний үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	III-IV улирал	ХШГ
<i>Төрийн захиргаа, хүний нөөц.</i>							
3.9.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;	Үйл ажиллагааны зардлаар	Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулсан байна.	Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу давхардсан тоогоор нийт 326 албан хаагчид 35 873 973 төгрөгийн буцалтгүй тусламж олгож 100 хувь биелсэн байна.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, бодит тусламжийг үзүүлсэн байна.	I-IV улирал	ТГ
3.10.	Ахмад настны нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг олгох журмыг хэрэгжүүлж ажиллах;	Ахмадын сангаас	Ахмад настны тухай хуулийн хүрээнд Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулах журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/09 дүгээр "Журам дүрэм шинэчлэн батлах тухай" тушаалын баталсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын хорооны дүрэм" болон "Ахмадын сангийн хөрөнгө зарцуулах журам"-д	Ахмад настнуудын нийгмийн баталгааг хангаж, холбогдох хууль журмын дагуу дэмжлэг тусламжийг олгосон байх, Ахмадын хорооны 2022 оны хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд анхаарч ажиллах	I-IV улирал	ТГ

				заасны дагуу 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 7,000,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг ахмад настнуудын ирүүлсэн өргөдөл хүсэлтийг үндэслэн олгосон байна.			
3.11.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах, ХАСУМ, мэдэгдэл тайлбарыг гаргуулах, салбарын албан хаагчдын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэх;	Шаард лагагүй	Хуулийн хугацаанд гаргасан байх	Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 788 албан хаагч байснаас 100 хувь буюу 788 албан хаагчийн 2020 оны ХАСХОМ гаргах ажлыг нийслэл, аймаг, дүүргийн 31 ЭБАТ-тай хамтран зохион байгуулсан. Үүнээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын 114 албан хаагчийн ХАСХОМ-ыг хугацаанд нь гаргуулж, баталгааны маягтыг бүртгэсэн. Хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 28-нд ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3, ХАСХОМ-4 тайлангуудыг салбарын хэмжээнд нэгтгэн гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.	ХАСХОМ-ыг салбарын хэмжээнд хуулийн хугацаанд 100% гаргасан байна.	I улирал	ТГ-ын ХХ
3.12.	Байгууллагын хэмжээнд авлигаас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагуудад хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх;	Шаард лагагүй	Зөвлөгөө өгсөн тоо	-Аймаг, нийслэл, дүүргийн ЭБАТ-уудад 1 дүгээр сард цахимаар сургалт зохион байгуулж, ХАСХОМ-ыг гаргах талаар чиглэл өгсөн. Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран аймаг, дүүргийн ЭХМКомиссын нийт гишүүдэд Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, сумдын байцаагч	Аймаг, нийслэл, дүүргийн ЭБАТ-уудад сургалт зохион байгуулж, ойлголт мэдээллийг нэмэгдүүлсэн байна.	I-IV улирал	ТГ-ын ХХ

				нарт “Ёс зүй, харилцаа хандлага”, Төрийн албаны тухай хуулийн талаарх сургалтуудыг бусад газруудтай хамтран зохион байгуулж давтагдсан тоогоор 800 албан хаагчдыг хамруулсан. - Салбарын албан хаагч, иргэн, төрийн бус байгууллагуудад хууль, эрх зүйн мэдээлэл зөвлөгөөг 250 гаруй удаа өгч ажилласан.			
3.13.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр гарч буй тушаал, шийдвэр, дүрэм, журмуудын талаар нэгдсэн бүртгэлтэй болж, холбогдох ажилтан, албан хаагчдыг нэгдсэн мэдээллээр хангаж ажиллах;	Шаард лагагүй	Захиргааны эрх зүйн актууд болон Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй тушаал, шийдвэр, эрх зүйн актуудыг нэгдсэн журмаар бүртгэлжүүлнэ.	Шинээр хэрэгжинэ.	Жилийн хугацаанд гарсан тушаал шийдвэр, эрх зүйн актуудыг нэгдсэн журмаар бүртгэлжүүлнэ.	I-IV улирал	ТГ-ын ХХ
<i>Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах.</i>							
3.14.	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Шаард- лагагүй	Хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн ажлын тоо	Хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав.	Хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	I-IV улирал	БХСГ СОНХАГ СБГ
3.15.	Казахстан болон Оросын холбооны улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой тооцоо, судалгаа хийх, санал боловсруулах, сурталчлах;	Шаард- лагагүй	Хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн ажлын тоо	Холбогдох ажлын хэсэгт ажиллаж, шаардлагатай тооцоо, судалгаа, саналыг хүргүүлэв.	Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажилласан байна.	I-IV улирал	БХСГ
3.16.	БНМАУ, ЗСБНХУ-ын	Үйл	Ажилласан хугацааг	2021 онд нийт 86 иргэний	Хэлэлцээрийн	I-IV	СОНХАГ



	хооронд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн Газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд иргэдийн ажилласан хугацааг баталгаажуулах;	ажил-лагаа ны зард лаар	баталгаажуулсан иргэдийн тоо -Боловсруулсан баримт бичгийн тоо, төрөл	хүсэлтийг холбогдох улсын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлэв. Аж ахуйн нэгж байгууллагад 121 иргэний материалыг албан бичгээр хүргүүлсэн. 125 иргэнийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгсөн байна.	хэрэгжилтийг хангаж, иргэдийн лавлагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна.	улирал	
3.17.	Олон улсын байгууллагатай хамтран ажиллах болон гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй ажлын бэлтгэл хангах;	Үйл ажил-лагаа ны зард лаар	-Боловсруулсан баримт бичгийн тоо, төрөл -Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, төрөл	Швейцарийн хөгжлийн агентлаг, Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA)-тай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлүүдийг боловсруулан баталж, хамтран ажиллах саналыг албан бичгээр хүргүүлсэн. Туркийн хамтын ажиллагаа зохицуулах агентлаг, Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (KOICA) -тай уулзалт зохион байгуулсан.	Олон улсын байгууллага, донор байгууллагуудтай хамтран ажиллаж, өөрсдийн үйл ажиллагааг танилцуулж сурталчилсан байна. Хамтын ажиллагааны гарцын талаар санал солилцсон байна.	I-IV улирал	СОНХАГ

*Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*

*"Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*

4.1.	ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Дэл хийн банкны төслийн	Чанарын удирдлагын тогтолцоонд шилжих, нэвтрүүлэх ажлын явцыг хянаж, удирдлага, арга зүйгээр хангах	2018 онд Төв, Орхон, 2019 онд Архангай, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, 2020 онд Сонгинохайрхан дүүрэг болон Баян-Өлгий, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, 2021 онд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс	Жилийн эцэст Нийгмийн даатгалын ерөнхий газар, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сүхбаатар, Хан-Уул,	I-IV улирал	ТГ-ын YAXX
------	--------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------	------------

		санхүү жилтээр		болон Булган, Дорноговь, Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүд үйл ажиллагаандаа Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэн батламжаа гардан авсан.	Чингэлтэй, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлсэн байна.		
4.2.	Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх;		-Байршуулсан мэдээ, мэдээлэл -Цахимаар мэдээлэл зөвлөгөө авсан иргэд даатгуулагчийн тоо	-Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөх зорилготой Фэйсбүүк хуудсыг 26,760 иргэн дагаж байгаа бөгөөд давхардсан тоогоор нийгмийн даатгалын талаарх мэдээлэлтэй танилцсан 1,156,467, эргэж холбогдсон 150,787, сэтгэгдэл үлдээсэн 4,531, бусдад түгээсэн 9,532 иргэн байна. Чатаар зурвас илгээсэн 16,180 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн. -Уг Фэйсбүүк хуудсаар нийгмийн даатгалтай холбоотой нийт 88 мэдээллийг зурган болон линк шэйрлэх хэлбэрээр оруулсан байна. -"Нийгмийн даатгал" гар утасны апплейкшнээр дамжуулж 4,914 иргэнд, ndaatgal.mn цахим хуудасны санал хүсэлт булангаар 727 иргэн, даатгуулагчид мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан байна.	Иргэдэд цахим хэлбэрээр мэдээлэл зөвлөгөө хүргэх хүрээг өргөтгөн, дагагчдын тоог нэмэгдүүлсэн, тэднийг нийгмийн даатгалтай холбоотой шинэ мэдээ, мэдээллээр тогтмол ханган ажилласан байна.	I-IV улирал	ТГ-ын YAXX
<p>"Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>							
4.3.	Нийгмийн даатгалын байгууллагын хүний	65,0 сая (Хичээл)	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан хүний	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж,	I-IV улирал	СОНХАГ

	нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;	үйлдвэрлэлийн дадлага)	ТОО	дээшлүүлэх 947 удаагийн сургалтад 16,310 албан хаагчийг хамруулсан.	албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтуудыг зохион байгуулсан байна.		
4.4.	Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх;	20,0 сая (Хичээл үйлдвэрлэлийн дадлага)	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Салбарын хэмжээнд зорилтот бүлэгт чиглэсэн 5,066 удаагийн сургалтад 6,513 аж ахуйн нэгжийн 193,948 иргэд, даатгуулагчийг хамруулсан. Мөн 596 удаагийн явуулын үйлчилгээ, нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, 288,543 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх, зорилтот сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна.	I-IV улирал	СОНХАГ
4.5.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах;	50,0 сая (Мэдээлэл сурталчилгааны зардал)	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн тоо	148 хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 641 удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан.	Олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай дамжуулж, мэдээлэл авах хүсэлт гаргасан хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангасан байна.	I-IV улирал	СОНХАГ-ын ОНХХ
4.6.	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэдэд ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэх; /Видео,постер.../	-	Шинэ контент бэлтгэсэн тоо	Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар 15 нэвтрүүлэг, 2 шторк, 14 видео хичээл нийт 31 видео контент, 198 постер, 7 төрлийн сурталчилгааны хуудас (брошур) шинээр бэлтгэн түгээсэн.	Шинэ контентийн агуулга, хэлбэрийг тодорхойлон бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон сошиал сүлжээгээр нэвтрүүлэн иргэд (даатгуулагч), ажил олгогчид хүргэсэн байна.	I-IV улирал	СОНХАГ-ын ОНХХ
"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
4.7.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээний чанар хүртээмжийг	10 сая	Сургалтын тайлан, хамрагдсан хүний тоо	2021 онд Өвөрхангай аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн болон	Сургалт зохион байгуулагдсан байна.	I-II улирал	ЭХМТК

	сайжруулах чиглэлээр орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, Эмнэлэг хөдөлмөрийн комиссын гишүүдэд сургалт зохион байгуулах;			Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт цахим сургалт зохион байгуулсан.			
4.8.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан болон дахин магадлалыг сонгогдсон аймаг, дүүрэгт зохион байгуулах;	35 сая	Хяналт шалгалтын дүн, тайлан	2021 онд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Завхан, Орхон, Хөвсгөл, Увс аймагт дахин магадлал, Баян-Өлгий, Баянхонгор, Сэлэнгэ аймагт хамтарсан магадлалыг зохион байгуулсан.	Батлагдсан хуваарийн дагуу аймаг, дүүрэгт хяналт шалгалт зохион байгуулсан байна.	I-IV улирал	ЭХМТК
4.9.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;	200.0 мян	Сонгон шалгаруулалтын тайлан, комиссын бүрэлдэхүүний тушаал	2018 онд сонгон шалгаруулалт зохион байгуулсан.	Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тушаалын төсөл боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	I улирал	ЭХМТК
<p><b>“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b></p>							
4.10.	Салбарын хэмжээнд хууль тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг мэдээллийн технологиор дэмжин ажиллах;	-	Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн дэвшилтэт технологид суурилан үзүүлэх үйлчилгээний хэвийн ажиллагааг хангасан байх	- Шинээр 2 систем нэвтрүүлсэн. - Ашиглагдаж буй 10 гаруй програм хангамжид нийт 110 орчим удаагийн өөрчлөлт, хөгжүүлэлт хийсэн.	2022 онд хэрэгжих хууль тогтоомжийн өөрчлөлтийг мэдээллийн технологид суурилан хэрэгжүүлэх зорилгоор одоо ашиглагдаж буй програм хангамжид өөрчлөлт оруулна. Шаардлагатай тохиолдолд шинээр мэдээллийн систем боловсруулж нэвтрүүлнэ. -“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,	I-IV улирал	МТТ

					тэтгэмжийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах; -"Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-ийн 19 <sup>2</sup> дүгээр зүйлийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах; -Шинээр хууль тогтоомж батлагдсан, өөрчлөлт орсон тохиолдолд хэрэгжилтийг хангах;		
4.11.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;	-	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлсэн байх	Шинээр хэрэгжинэ	-Нийгмийн даатгалын салбарын бүх байгууллагуудад мэдээллийн шинэчилсэн системийг нэвтрүүлсэн байна. -Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг бодит цагийн горимоор үзүүлнэ.	I-IV улирал	МТТ
4.12.	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх;	-	1. Нэгдсэн мэдээллийн санг 2022 оны мэдээллээр баяжуулах 2. Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийх 3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах 4. Төрийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэх	1. 74GB нэгдсэн мэдээллийн сан үүссэн. 2. 210 удаагийн мэдээллийн боловсруулалт хийсэн. 3. Цахимаар үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээ: -"Нийгмийн даатгал" аппликейшнийг 207.2 мянган даатгуулагч идэвхитэй ашигласан. -"Даатгуулагчдад зориулсан вэб" системд 1.7 сая удаагийн хандалт хийж, цахимаар үйлчилгээ авсан. -ТҮЦ машинаас 130.5 мянган лавлагаа тодорхойлолт хэвлэн авсан. -E-mongolia төрийн цахим	1. Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх, төрийн нэгдсэн мэдээллийн санд байршуулах, нэгдсэн мэдээллийн сангаас үйлчилгээ үзүүлэх ажил тогтвортой хийгдсэн байна. 2. Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийх ажлыг цаг тухай бүр гүйцэтгэсэн байна. 3. Иргэд даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад "Нийгмийн даатгал" аппликейшн, "Даатгуулагчид зориулсан вэб", ТҮЦ машин, төрийн	I-IV улирал	МТТ


				<p>үйлчилгээний нэгдсэн порталаар нийгмийн даатгалын 3 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар хүргэж, сайн дурын даатгалын үйлчилгээг нэмж оруулсан.</p> <p>4. Цахимаар мэдээлэл солилцох төрийн байгууллагын тоог 3-аар нэмэгдүүлж, нийт 16 төрийн байгууллагад цахим мэдээлэл хүргүүлэх үйлчилгээ хэвийн явагдсан.</p>	<p>цахим үйлчилгээний e-mongolia нэгдсэн порталаар дамжуулан цахимаар үзүүлэх мэдээллийн үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.</p> <p>4. Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан төрийн байгууллагатай мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна.</p>		
4.13.	Эмнэлгийн хуудсыг цахимаар солилцох, иргэд даатгуулагчдад тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх;		Эмнэлгийн хуудсаар тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байх	Эрүүл мэндийн байгууллагаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авах бэлтгэл ажил хангагдсан.	<p>- Эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг ажил олгогч болон даатгуулагч цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>- Ажил олгогч тэтгэмжийн тайлангаа нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>- Даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.</p> <p>- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн амаржсаны тэтгэмж</p>	I улиралд нэвт рүүлж, жилийн турш хэвийн ажилла гаг хангах	МТТ

26

					олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдсан байна.		
4.14.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоолгох өргөдөл, материалыг даатгуулагчаас цахимаар хүлээн авч, шийдвэрлэх ажлыг эхлүүлэх;		Тэтгэвэр тогтоолгох хүсэлт, материалыг цахимаар хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байх	Шинээр хэрэгжинэ.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд шинээр нэвтрүүлэх цогц системийг ашиглан даатгуулагч тэтгэвэр тогтоолгох хүсэлт, холбогдох баримт материалаа нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна.	III-IV улирал	MTT
4.15.	Даатгуулагчдад ажилгүйдлийн тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар хүргэх;		Ажилгүйдлийн тэтгэмж олгох үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байх	"Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдөл"-ийг цахимаар хүлээн авах системийг хөгжүүлж нэвтрүүлсэн.	-Даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлсэн байна. - Ажилгүйдлийн тэтгэмж олголтын үйлчилгээг зайнаас үзүүлэх нөхцөл хангагдсан байна.	I улиралд нэвт рүүлж, жилийн турш хэвийн ажилла гаг хангах	MTT

Төсвийн шууд захирагч:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА



/Дондовын Зоригт/